Шинжлэх ухаан, технологийн их сургууль нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй, Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг мөрдсөн байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.

Мөн 2019 оны А/737 дугаар тушаалаар төрийн өмчит их сургуулийн эрдэмтэн багш нарын бүрэлдэхүүнтэй байгуулагдсан ажлын хэсэг Төрийн өмчит их дээд сургуульд мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулсан бөгөөд салбарын бодлогын баримт бичигт тусгай бүлэг болгон оруулсан байна.

БШУС-ын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/220 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

Хяналт шалгалтаар нийт 37 асуудлыг алдаа зөрчилтэйд тооцож, 27 зөвлөмж, 4 акт, албан шаардлага өгөх санал гаргаж, 180.3 сая төгрөгийн зөрчилөөс 39.4 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, нийт 14 зөвлөмж өгч ажилласан.

Мөн Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дотоод аудитын газар 2020-2021 оны төлөвлөгөөний дагуу 8 чиглэлээр 4 бүрэлдэхүүн сургуульд хяналт шалгалт хийж нийт 365.8 сая төгрөгийн 20 зөрчил илрүүлж, зөвлөмж өгч ажилласан байна.

Төлөвлөгөөт бусаар төлбөрийн буцаалт өндөртэй 4 бүрэлдэхүүнд сургуульд 2017-2021 оны 8 сар хүртэл хяналт шалгалт хийж нийт 46.8 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага, өгч бүрэлдэхүүн сургуулиуд өгсөн албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт орлогын 49,285.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 492.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн тоон үзүүлэлт өмнөх оноос материаллаг зөрүүтэй байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 68,401.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 684.0 сая төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,500.3 сая төгрөгөөр буюу 10.5 хувиар өсөж, материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөрийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| | /сая төгрөг/ | | |
|---|------------------|------------------|-----------------|
| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 23,762.1 | 24,785.1 | 1,023.0 |
| Авлага | 4,207.9 | 3,940.3 | (267.6) |
| Урьдчилгаа | 752.5 | 776.5 | 24.0 |
| Бараа материал | 1,907.9 | 2,217.5 | 309.6 |
| Үндсэн хөрөнгө | 107,916.3 | 121,327.6 | 13,411.3 |
| Нийт хөрөнгө | 138,546.8 | 153,047.1 | 14,500.3 |
| Богино хугацаат өр төлбөр | 9,442.5 | 10,273.8 | 831.3 |
| Урт хугацаат өр төлбөр | 57.2 | 52.2 | (5.0) |
| Төрийн өмч | 30,341.5 | 30,567.5 | 226.0 |
| Хуримтлагдсан үр дүн | 37,597.4 | 51,047.3 | 13,449.9 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 61,108.3 | 61,106.3 | (1.9) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 138,546.8 | 153,047.1 | 14,500.3 |

Мөнгөн хөрөнгө данс 1,023.0 сая төгрөгөөр өссөн нь 12 дугаар сарын эцэст харилцахад орж ирсэн БЗС-аас олгосон сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжийн санхүүжилт, Ерөнхийлөгчийн тэтгэлгийн санхүүжилт, Койка төслөөс орсон хандивын орлого болон болон жилийн эцсийн харилцахын үлдэгдэлд бодогдсон хүүгийн орлогоос шалтгаалсан байна.

Голомт банканд 13,946.5 сая төгрөг, Улаанбаатар хотын банканд 2,080.4 сая төгрөг, ХААН банканд 5,157.5 сая төгрөг, Төрийн банканд 259.6 сая төгрөг, Үүнээс гадна гадаад валют болон хадгаламж Голомт банкны дансанд 341.0 сая төгрөг, ХААН банканд 3,000.0 сая төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл 3,940.3 сая төгрөг болж 267.6 сая төгрөгөөр буурсан нь БЗС-ийн буцалтгүй тусламжаар суралцагчдын сургалтын төлбөрийн 744.7 сая төгрөгийн авлага буурснаас шалтгаалжээ.

Авлагын үлдэгдэлд тайлант онд үүссэн 1,581.9 сая төгрөг, 1-2 жилийн насжилттай 472.5 сая төгрөг, 3-аас дээш жилийн насжилттай 1,651.2 сая төгрөг байгаа ба найдваргүй 234.7 сая төгрөгийн авлагаас байгууллагаас авах авлага 5.1 сая төгрөг, сургалтын төлбөрийн авлага 229.6 сая төгрөг байна.

Урьдчилж төлсөн зардлын данс 776.5 сая төгрөг болж, 24.0 сая төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа 259.3 сая төгрөгөөр өссөн, бараа материал бэлтгэх, төсөл гэрээт ажлын зардал, бусад урьдчилгааны нийт 213.2 сая төгрөгийн буурснаас шалтгаалжээ.

Тайлант онд бараа материал өөрийн хөрөнгөөр худалдан авсан 1,791.7 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 362.2 сая төгрөг, бусад орлогоор 0.8 сая төгрөг, нийт 2,155.3 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, 2,217.5 сая төгрөг болж, 309.6 сая төгрөгөөр өссөн.

Биет хөрөнгийн данс нь өөрийн хөрөнгөөр худалдан авсан 2,157.1 сая төгрөг, төслийн хандиваар авсан 11,152.7 сая төгрөг, өмнөх онд худалдан авахаар төлбөр нь шилжсэн хөрөнгө 67.7 сая төгрөг, Боловсролын үнэлгээний төвөөс ТӨХ-н шийдвэрээр шилжиж ирсэн 24.4 сая төгрөг, бараа материалаас шилжүүлсэн 13.7 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 113,020.0 сая төгрөг болж 12,559.6 сая төгрөгөөр өссөн нь гадаадын зээл тусламжаар авсан хөрөнгө 10,742.8 сая төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 503 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож бүртгэж 7,708.2 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ. Мөн ТӨБЗГ-ын А-1/919 болон 216 тогтоолоор нийт 964.9 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан, элэгдлийн зардал 8,258.4 сая төгрөгөөр хорогдсон байна.

Биет бус хөрөнгө 8,307.6 сая төгрөг болж 851.7 сая төгрөгөөр өссөн нь төслөөс хандивын хөрөнгө 230.3 сая төгрөг, өөрийн хөрөнгөөр худалдан авсан 57.6 сая төгрөг, хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгаж, үнийг шинэчлэн тогтоосон 474.9 сая төгрөг, төсөл, гэрээт ажил болон сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлогын өсөлт 584.1 сая төгрөг, БЗС-аас олгосон Ерөнхийлөгчийн тэтгэлгийн санхүүжилтийн 440.0 сая төгрөгөөс шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр нь төрийн байгууллагын дулааны шугам сүлжээг шинэчлэх сайжруулах ТӨХ-ны шийдвэрээр сангийн яам болон Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй хийгдсэн ажлын төлбөрийн Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-д төлөхөөр үүссэн 52.2 сая төгрөгийн өр төлбөр байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 142,721.1 сая төгрөг болж 13,674.0 сая төгрөгөөр өссөн нь төрийн өмч, хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ. Үүнд:

- Төрийн өмчийн дансны үлдэгдэл 30,567.5 сая төгрөг болж 226.0 сая төгрөгөөр өссөн нь Оюутны IV байрны 6,980 мкв газрын дахин үнэлсэн;
- Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 61,106.3 сая төгрөг болж 1.9 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын тогтоолоор хөрөнгийг акталж, данснаас хассан, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосон;
- Өмнөх үеийн хуримтлагдсан үр дүн 37,575.7 сая төгрөг болж 1,811.3 сая төгрөгөөр буурсан нь найдваргүй авлагаар тооцож хассан 0.4 сая төгрөгийн авлага эргэн төлөгдсөн, авлага 15.8 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдэл 13.9 сая төгрөгөөр буурч, урьдчилгаа 1.4 сая төгрөгөөр нэмэгдэж, өр төлбөр болон урьдчилж орсон орлого 13.9 сая төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний хэрэгжилт 1.9 сая төгрөгөөр нэмэгдсэн, орлого 6.5 сая төгрөгөөр бууруулсан бичилт хийж залруулсанаас шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2021 оны төсвийн төлөвлөлтийг удирдах зөвлөлийн 2020 оны 16 тоот тогтоолоор үйл ажиллагааны орлого, зарлагын төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөг баталж, 2021 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн 07 тоот тогтоолоор тодотгосон.

Тайлант оны үйл ажиллагааны орлогыг 49,167.3 сая төгрөгөөр, өмнөх оны шилжих үлдэгдлээс 10,574.1 сая төгрөгөөр, нийт орлогыг 59,741.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 59,520.7 сая төгрөгөөр баталсан байна.

Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 3,392.4 сая төгрөгийг төлөвлөж, ТӨБЗГ-ын 2020 оны 724 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 50,049.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 101.8 хувийн гүйцэтгэлтэй, нийт 49,026.5 сая төгрөгийн зардал гаргаж, 1,023.0 сая төгрөгийн үр дүнтэй байна.

Үүнээс сургалтын төлбөрийн орлогоор 49,336.2 сая төгрөг, МСҮТ-ийн хувьсах зардлын санхүүжилтийн орлогоор 589.0 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 124.3 сая төгрөгийг бүрдүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

ШУТИС-ийн хариуцлагын хэлбэр, статус тодорхой бус, мөн санхүүгийн тайлангаа нэгтгүүлдэг бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд болон нэгдсэн тайлан гаргадаг Санхүү, нягтлан бодох бүртгэлийн асуудал хариуцсан газар, алба нь төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байгаа тул холбогдох дээд шатны байгууллагуудад санхүүгийн тайлан гаргах, нэгтгэхэд хүндрэлтэй байна.

Тус байгууллага өмнөх оны шилжих үлдэгдлээс тайлант оны орлогыг санхүүжүүлэхээр төсөвлөж, тайлант оны орлогын төлөвлөгөөг тухайн жилийн зардлаас дутуу төсөвлөж байгаа нь зардлын төлөвлөлтөнд анхаарал хандуулахад хүргэж байна. Дийлэнх бүрэлдэхүүний сургуулиудын хувьд ШУТИС-ийн нэг оюутанд ногдож буй зардал нь батлагдсан дунджаас дээгүүр байна.

3.8 Аудитын гол асуудал

ШУТИС-ийн Үйлдвэрлэл технологийн сургууль, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулиудын газартай холбоотой маргаан шийдвэрлэгдээгүй байна. БШУЯ-наас хийсэн шалгалтын дүнд уг асуудлыг холбогдох захиргаа, хууль, шүүхийн байгууллагад хандаж, үндэслэл, баримт нотолгоог бүрэн гаргаж өгч, түргэн шуурхай шийдвэрлүүлэх зөвлөмжийг БШУЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас хүргүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд харьяа бүрэлдэхүүн 21 сургуулиуд нь тайлант онд шилэн дансны цахим хуудсанд байршуулах ажил гүйлгээний 2351 мэдээллээс 16 мэдээлэл хугацаа хоцроосон, 5 сая төгрөгөөс дээш нийт 108,416.5 сая төгрөгийн ажил гүйлгээний мэдээ оруулахаас 25.9 сая төгрөгийн 4 мэдээг хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол мэдээлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 516.1 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илрүүлснээс аудитын явцад 58.3 сая төгрөгийн 3 алдааг залруулсан.

Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтаас албан шаардлагын биелэлт 97.9 хувь, зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувь, нийт 90.6 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | Хувь |
|-----------------|---------------------|--------------|----------|--------------|----------|----------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Албан шаардлага | 3 | 82.8 | 2 | 82.8 | 1 | | 97.9 |
| Зөвлөмж | 3 | 188.4 | 2 | 188.4 | 1 | | 83.3 |
| Нийт дүн | 6 | 271.2 | 4 | 271.2 | 2 | 0 | 90.6 |

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжөөс шилэн дансны цахим хуудсанд 59 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсөл гэрээт ажилтай холбоотой асуудалд БШУЯ-ны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянах, гэрээт ажлын гүйцэтгэлийг тусгайлан авч үзэх, мөн худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байгаа эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 465.8 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 227.0 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 213.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 25.1 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 238.8 сая төгрөгийн алдаа, зөрчил нь материаллаг байдлын түвшин 684.0 сая төгрөгөөс бага тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Эдийн засгийн ангиллын дагуу 13.4 сая төгрөгийн зардлыг бүртгээгүй, бүлэг хооронд шилжүүлэн тайлагнасан;
- Тайлант оны 105.4 сая төгрөгийн төсөл, гэрээт ажлын авлагыг дутуу бүртгэсэн;
- Боловсрол шинжлэх ухааны яамны санхүүжилтээр спорт заал засварласан 108.2 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгээгүй байсныг тайлагнасан.

4.2 Албан шаардлага

1. Байр түрээслүүлэх гэрээгүйгээр 24 багш, ажилтнаас түрээсийн төлбөрт нийт 31.3 сая төгрөгийн орлого авсныг санхүүгийн тайланд бүртгэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх” журам, ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Багш ажилчидтай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага өгөх.

2. Гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулаагүй, гэрээ дүгнэсэн актгүй 41.2 сая төгрөгийн урсгал засварын ажил гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх” журам, ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй мөн санхүүгийн тайлагналын “тохиолдсон байх” ба “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид урсгал засварын ажлын гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгаруулан, гэрээг дүгнэж ажиллах, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

3. Салбар сургуулийн ойн арга хэмжээний зардалд 22.1 сая төгрөг, спортын уралдаан тэмцээний зардалд 13.6 сая төгрөг, албан конторын тавилга худалдан авахад 105.4 сая төгрөг, нийт 141.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх”, 1.4-д “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт

хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх", 1.6-д "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагаас авах нийт 22.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дах заалтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, аудитаар өгсөн зөвлөмжийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.

2. Төсвийн зарцуулалттай холбоотой

Илрүүлэлт:

Гадаадад доктор хамгаалахаар явсан багшийн тусгаарлах байрны төлбөрт 2.4 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй мөн санхүүгийн тайлагналын "тохиолдсон байх" ба "эрх үүрэг" батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/Д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|------------------|------------------------|---|---|--------------------------|-----------|-----------|-----------|-----|-----|-----------------|-----|-------------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | ШУТИС | АХГ-2022/07/НА-СТА-ТӨА | Эдийн засгийн ангиллын дагуу 13.4 сая төгрөгийн зардлыг бүртгээгүй, бүлэг хооронд шилжүүлэн тайлагнасан | Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх, зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй ажиллах | 1 | 13,381.8 | 1 | 13,381.8 | | | | | | | | |
| 2 | ШУТИС | АХГ-2022/07/НА-СТА-ТӨА | Тайлант оны 105.4 сая төгрөгийн төсөл, гэрээт ажлын авлагыг дутуу бүртгэсэн | Авлагыг бүртгэж залруулсан, цаашид НББ тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах | 1 | 105,390.8 | 1 | 105,390.8 | | | | | | | | |
| 3 | ШУТИС | АХГ-2022/07/НА-СТА-ТӨА | Боловсрол шинжлэх ухааны яамны санхүүжилтээр спорт заал засварласан 108.2 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгээгүй байсныг тайлагнасан | Үндсэн хөрөнгөд бүртгэж залруулсан, цаашид НББ тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах | 1 | 108,239.7 | 1 | 108,239.7 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|-------|------------------------|--|---|---|-----------|--|--|--|--|---|-----------|--|--|--|---|----------|
| 4 | ШУТИС | АХГ-2022/07/НА-СТА-ТӨА | Байр түрээслүүлэх гэрээгүйгээр 24 багш, ажилтнаас түрээсийн төлбөрт нийт 31.3 сая төгрөгийн орлого авсныг санхүүгийн тайланд бүртгэсэн байна | Багш ажилчидтай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах | 1 | 31,340.0 | | | | | 1 | 31,340.0 | | | | | |
| 5 | ШУТИС | АХГ-2022/07/НА-СТА-ТӨА | Гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулаагүй, гэрээ дүгнэсэн актгүй 41.2 сая төгрөгийн урсгал засварын ажил гүйцэтгүүлсэн байна | Цаашид урсгал засварын ажлын гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгаруулан, гэрээг дүгнэж ажиллах, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх | 1 | 41,140.2 | | | | | 1 | 41,140.2 | | | | | |
| 6 | ШУТИС | АХГ-2022/07/НА-СТА-ТӨА | Салбар сургуулийн ойн арга хэмжээний зардалд 22.1 сая төгрөг, спортын уралдаан тэмцээний зардалд 13.6 сая төгрөг, албан конторын тавилга худалдан авахад 105.4 сая төгрөг, нийт 141.1 сая төгрөгийг зарцуулсан байна | Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх | 1 | 141,169.5 | | | | | 1 | 141,169.5 | | | | | |
| 7 | ШУТИС | АХГ-2022/07/НА-СТА-ТӨА | Байгууллагаас авах нийт 22.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар | Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, аудитаар өгсөн зөвлөмжийг давтан гаргахгүй байх, | 1 | 22,733.7 | | | | | | | | | | 1 | 22,733.7 |

| | | | | | | | | | | | | | | | | |
|--|-------|------------------------|--|--|---|-----------|---|-----------|---|---|---|-----------|---|---|--------|----------|
| | | | баталгаажуулаагүй байна | хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах | | | | | | | | | | | | |
| 8 | ШУТИС | АХГ-2022/07/НА-СТА-ТӨА | Гадаадад доктор хамгаалахаар явсан багшийн тусгаарлах байрны төлбөрт 2.4 сая төгрөг зарцуулсан байна | Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж зөрчлийг давтан гаргахгүй байх | 1 | 2,402.5 | | | | | | | | 1 | 2402.5 | |
| Дүн | | | | | 8 | 465,798.2 | 3 | 227,012.3 | 0 | 0 | 3 | 213,649.7 | 0 | 0 | 2 | 25,136.2 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | ШУТИС | АХГ-2022/07/НА-СТА-ТӨА | Харьяа бүрэлдэхүүн 21 сургуулиуд нь тайлант онд шилэн дансны цахим хуудсанд байршуулах ажил гүйлгээний 2351 мэдээллээс 16 мэдээлэл хугацаа хоцроосон, 5 сая төгрөгөөс дээш нийт 108,416.5 сая төгрөгийн ажил гүйлгээний мэдээ оруулахаас 25.9 сая төгрөгийн 4 мэдээг хоцроосон байна | Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол мэдээлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх | 1 | 25,946.3 | | | | | 1 | 25,946.3 | | | | |
| Дүн | | | | | 1 | 25,946.3 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 25,946.3 | 0 | 0 | 0 | 0 |
| Нийт дүн | | | | | 9 | 491,744.5 | 3 | 227,012.3 | 0 | 0 | 4 | 239,596.0 | 0 | 0 | 2 | 25,136.2 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 368/АД/50058
АХГ-2022/07/МА-СТЭ-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулаагүй, гэрээ дүгнэсэн актгүй 41,170,190.00 төгрөгийн урсгал засварын ажил гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно", 33.2.2 "техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендэрт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Цаашид урсгал засварын ажлын гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгаруулан, гэрээг дүгнэж ажиллах, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Намнан, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга Д.Барсболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АМГАЛАН АХУЙ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Д.АМГАЛАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 1 багц тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

11/0.10.10.20/Bichig_Khereg/Alban_Shaardlaga/2022/0315_Auditin_2_Gazar-42.Docx

0010801065



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 369/АО/50058

Улаанбаатар хот

АХГ-2022/07/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байр түрээслүүлэх гэрээгүйгээр 24 багш, ажилтнаас түрээсийн төлбөрт нийт 31,340,000.00 төгрөгийн орлого авсныг санхүүгийн тайланд бүртгэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх" журам, ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Багш, ажилчидтай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Намнан, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга Д.Барсболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АМГАЛАН АХУЙ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Д.АМГАЛАН



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\0.10.10.20\Bicigt_Khereg\Alban Shaardlaga\2022\03\5_Auditin 2 Газар-41.Docx

0010821063



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 366/АД/50058

Улаанбаатар хот

АХГ-2022/07/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа бүрэлдэхүүн 21 сургуулиуд нь тайлант онд шилэн дансны цахим хуудсанд байршуулах ажил, гүйлгээний 2351 мэдээллээс 16 мэдээлэл хугацаа хоцроосон, 5 сая төгрөгөөс дээш нийт 108,416,530,000.00 төгрөгийн ажил, гүйлгээний мэдээ оруулахаас 25,946,300.00 сая төгрөгийн 4 мэдээг хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ ... таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол мэдээлэх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Намнан, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга Д.Барсболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АМГАЛАН АХУЙ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Д.АМГАЛАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-204230

\\10.10.10.201\ichig_Kherge\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-44.Docx

00108C1069



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 367/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/07/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Салбар сургуулийн ойн арга хэмжээний зардалд 22,098,668.00 төгрөг, спортын уралдаан тэмцээний зардалд 13,622,867.13 төгрөг, албан конторын тавилга худалдан авахад 105,447,959.00 төгрөг, нийт 141,169,494.13 төгрөгийг зарцуулсан байна.


Энэ нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх", 1.4 "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх", 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Намнан, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга Д.Барсболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АМГАЛАН АХУЙ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Д.АМГАЛАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-43.Docx

0010801081

